



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 11662

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 90 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй тодорхой нэр төрлийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн системд хөгжүүлэлт хийж нэвтрүүлэх, цахим аймаг бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлах, “E-Mongolia.mn” болон бусад цахим системийн ашиглалтын талаар иргэд, олон нийтийг заавар зөвлөмжөөр хангах, “Цахим Өвөрхангай” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулахад 4,520,930 (дөрвөн сая таван зуун хорин мянга есөн зуун гуч) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 4,520,930 (дөрвөн сая таван зуун хорин мянга есөн зуун гуч) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд-д) зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0563